

## БНМАУ-ЫГ НҮБ-Д ЭЛСҮҮЛЭХЭД АНУ ҮЛ ТАТГАЛЗАЖ ТАЙВАНЬ ХОРИГ ТАВИАГҮЙН ЦААД ШАЛТГААН

*T. Төмөрхүлэг \**

**M**онгол улсыг НҮБ-д элсүүлэх асуудал 1961 оны 10 дугаар сард Аюулгүйн Зөвлөлийн хуралдаанаар төвөггүй шийдэгдсэн, үүнд БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэхийн эсрэг арав гаруй жил амь тавин тэмцэж байсан Тайваний засгийн газар хориг тавихгүй болсны учир начрыг магадлууштай. Манай улсын судлаачид Гоминданы Хятад эцсийн бүлэгт БНМАУ-ыг НҮБ-ын бүрэн эрхт гишүүнээр элсүүлэхээс өөр аргагүйд тулсан гэж ерөнхийлөх юмуу, эсвэл “Хэрэв НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд Чан Кайшигийн Хятад Монголыг элсүүлэхэд хориг тавибал ЗХУ Мавританыг элсүүлэхэд мөн хориг тавьж болох байв... Асуудал иймэрхүүгээр эргэвэл Африкийн орнууд НҮБ-ын гишүүн бусад улсуудтай хүч хавсран Чан Кайшигийн Хятадыг НҮБ-аас зайлцуулж НҮБ болон НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд БНХАУ-ын хууль ёсны эрхийг эдлүүлэхэд хүргэх байлаа. Энэ нь өрнөдийнхний, тухайлбал АНУ-ын бодлогод нийцэхгүй байсан учир Чан Кайшигийн төлөөлөгчдийг НҮБ-д авч үлдэхийн тулд манай улсыг НҮБ-д элсүүлэхээс өөр аргагүй болсон байна”<sup>1</sup> гэх зэргээр ярьж, бичиж, сурталчилсаар ирсэн. Энэ нь уул асуудлын өнгөн тал нь байжээ.

Хэргийн мөн учир нь (1947-1960 он хүртэл) Монголын асуудал сөхөгдөх бүр эрс тэrs төдийгүй тэчьяадан эсэргүүцдэг байсан Чан Кайшигийн төлөөлөгчид байр сууриа яагаад тийнхүү огцом өөрчлөх болов гэдэгт байгаа юм. Мөн манай зарим нэг түүхч-сэтгүүлчийн нэлээд олон жилийн өмнө хэвлэлд бичсэнээр “АНУ Монголыг НҮБ-д оруулахгүйн үүднээс Чан Кайшигийн урвагч бүлгийг ашиглаж байсан юм”<sup>2</sup> гэсэн бол АНУ мөн 1961 онд Монголыг НҮБ-д авахгүй гэж яагаад татгалзсангүй вэ гэдэг асуудал бас босоод ирнэ. Тэгвэл энэ хоёр асуултад арай өөр хариулт хайх хэрэгтэй юм.

Үүнд Монголын гадаад харилцааны түүхийг тодруулахад Өрнөдийн орнуудын дипломат баримт бичиг, тухайлбал архивын хэрэглэгдэхүүнийг цуцалтгүй эрэн сурвалжлах шаардлагатай байгаа юм. Миний бие 2004 онд Францын ГХЯ-ны архивын Монголын сан хөмрөгт Монголыг НҮБ-д элссэнтэй холбогдох нэгэн баримт бичиг үзсэн билээ. Энэ бол Токиогоос Францын Элчин сайд 1961 оны 8 дугаар сарын 24-нд ГХЯ-ндаа илгээсэн нууц мэдээлэл юм. Эл мэдээлэлд “Чэн Чэнь /Тайваний дэд ерөнхийлөгч/, Кеннеди /АНУ-ын ерөнхийлөгч Жон Ф. Кеннеди/ хоёр саяхан уулзахдаа Монголын асуудлаар үнэнхүү эвлэрэлд хүрсэн бололтой байна. Үүнд АНУ-ын засгийн газар БНМАУ-

\* МУИС, ОУХС-ийн дэд профессор, доктор (Ph.D)

<sup>1</sup> С. Ишдорж, “Кремлээс ногоон гэрэл ассаны дараа” өгүүлэл, Үндэсний дэвишил сонин, 1992. 09.30, № 21

<sup>2</sup> Д. Наранцэцэг, статья “О том, как Монголия стала членом ООН”, газета Новости

Монголии от 8 Декабря 1990

ыг түр хугацаагаар хүлээн зөвшөөрөхөө огоорсон тул Тайваний засгийн газар тус улсыг НҮБ-д элсэн ороход огт хориг тавихгүй гэсэн үүрэг авсан бололтой байна. Сайх мэдээг АНУ-ын ЭСЯ-ны нэгэн гишүүн манай ЭСЯ-ны нэгэн ажилтанд ярьжээ”<sup>3</sup> гэсэн байна. Энэ нь Монгол улс НҮБ-д элсэхээс бүтэн хоёр сарын өмнө Токиогоос Парис руу явуулсан мэдээ юм. Үүнийг би өргөн олон уншигчдад сонин байх болов уу гэж бодон “Монголын мэдээ” сонины 2005 оны 11 дүгээр сарын 19-ний дугаарт нийтлүүлж байсан юм.

БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх асуудал хэлэлцсэн Ерөнхий Ассамблейн 17 дахь удаагийн чуулган хуралдахаас гурван сарын өмнө буюу 1961 оны зургадугаар сард Москва дахь АНУ-ын түр хамарагч Э. Фрийтц манай улсын элчин сайд С.Лувсантай уулзаж БНМАУ-тай дипломат харилцаа тогтоохыг сэдэн саналаа илэрхийлснийг гадаад харилцааны түүхчид, манай дипломат ажилтнууд цөм мэдэх билээ. Монголын засгийн газар хариуд нь АНУ-тай дипломат төлөөлөгчдийн газраа солилцохыг зөвшөөрч, энэ асуудлаар хэлэлцээ хийхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн. Үүнтэй холбогдох баримт сэлт одоо манай ГХЯ-ны архивт буй. Гэвч удалгүй Тайваний эрх баригчид БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөхийг эсэргүүцсэн учир Монголтой дипломат харилцаа тогтоохыг Төрийн Департамент хойшлууллаа гэж зарласан. Чингэхээр АНУ Монголыг НҮБ-д элсэхэд татгалзагүй мөртлөө хориг тавиагүй Чан Кайшигийн дэглэмийн үгэнд орж дипломат харилцаа тогтоохоо хойшлуулжээ гэдэг асуудал эрхбиш сонирхол татах учиртай.

ЗХУ, БНХАУ-ын харилцаа тавиад оны сүүлч, жараад оны эхээр хүйтэрч улмаар ноцтойгоор эргэж хөрвөж болох шинж мэдэгдмэгц АНУ-ын Төрийн Департамент Монголтой дипломат харилцаа тогтоохыг сэдсэн нь маргах зүйлгүй. Түүхийн шинжлэх ухааны доктор Равдангийн Болдын 2008 онд хэвлүүлсэн “Монголын тусгаар тогтнол ба Америкийн Нэгдсэн Улс” хэмээх номын 17-20 дахь хавсралтууд Чэн Чэнь, Кеннеди хоёрын Монголын талаар хэлэлцэж эцсийн бөлөгт тохиролцоонд хүрснийг давхар нутлаж буй үнэ цэнэтэй баримт бичгүүд юм. Эдгээр хэрэглэгдэхүүнийг доктор Р.Болд АНУ-ын Үндэсний Архиваас олж судалгааны эргэлтэнд оруулсан нь олзуурхууштай. Үүнд Жон Кеннеди 1961 оны 7 дугаар сарын 14-нд Чан Кайшид илгээсэн нууц захидалдаа “Ар Монголын асуудалтай холбогдуулан танд мэдээлэхэд өрнөдийн дипломат төлөөлөгчдийг Зөвлөлт Орос, Хятадын эх газрын хооронд орших бус нутагт илгээх нь Чөлөөт ертөнцөд стратегийн ямар давуу байдал олгож болохыг л судлах зорилготой юм. ... Ар Монголыг НҮБ-ын гишүүнээр элсэхэд танай төлөөлөгч хориг тавихаас зайлсхийх арга замыг олно гэдэгт тань бид найдаж байна”<sup>4</sup> гээд уг асуудлаар хэлэлцээ хийх төлөөлөгчөө Вашингтонд ирүүлэхийг санал болгожээ. Чингээд Тайваний дэд өрөнхийлөгч Чэн Чэнь Вашингтонд очиж өрөнхийлөгч Кеннедитэй хэлэлцээ хийсэн ажээ. Уг хэлэлцээ 1961 оны 8 дугаар сарын 1-нд болсон байна. Протоколоос нь үзвэл Монголыг НҮБ-д элсүүлэх гэсэн Америкийн байр суурь баахан шавдангуй шинжтэй. Жишээлбэл уг хэлэлцээнд оролцсон Төрийн нарийн бичгийн дарга Раск, НҮБ-д коммунист Хятадыг байлгаснаас Ар Монголыг байлгасан нь дээр юм биш үү гэж Чэн Чэньд тулгах маягийн асуулт тавьж байжээ. Дараа нь буюу 10 дугаар сарын 2-нд Чан Кайши Монголын асуудлаар АНУ-ын Элчин сайд Драмрайтай халуухан яриа

<sup>3</sup> Archive du Ministère des Affaires Etrangères de la France (AMAEF). Mongolie 1956-1967 bis-23-10

<sup>4</sup> Равдангийн Болд, “Монголын тусгаар тогтнол ба Америкийн Нэгдсэн Улс”, Улаанбаатар, 2008, хавсралт № 17, 18, 373-376 дахь тал

өрнүүлсэн байна. Элчин сайд Тайваний ерөнхийлөгчийн асар гомдонгуй өнгө аястай тулгасан олон асуултад үл шантран “... Ар Монголын асуудлаар санал хол зөрөөтэй байгаагаас АНУ тухайн нөхцлөөс шалтгаалан шийдвэр гаргах байр суурьтай байна”<sup>5</sup> хэмээн зоримог хариулсан аж. Гол нь Монголыг НҮБ-д элсүүлэхэд Тайванийг хориг тавиулахгүй байлгахад Америкийн бодлого чиглэжээ. Эцсийн бөлөгт Кеннедигээс Чан Кайшид 10 дугаар сарын 5-нд явуулсан захидаар уг асуудлыг шууд тулгасан байна. Ерөнхийлөгч Кеннеди эл захидалдаа “Миний бие эдүгээгийн нөхцөл байдалд Ар Монголын талаарх зөрөлдөөнтэй асуудлаа -та хориг тавихгүйгээр, -бид дипломат шинэ санаачлага гаргахгүйгээр (Монголтой дипломат харилцаа тогтоохоо тодорхой бус хугацаагаар хойшлуулах) шийдвэрлэж болно гэж үзэж байна”<sup>6</sup> хэмээн дурджээ.

Ийнхүү Монголыг НҮБ-д элсүүлэхэд АНУ үл татгалзаж, Тайвань хориг тавиагүйн цаад шалтгааны учиг тайлагдаж байгаа хэрэг юм. Нэгэн үгээр Монголын талаарх АНУ, Тайваний зөрчил түр хугацааны эвлэрлээр шийдэгдсэн бөгөөд Токио дахь Францын Элчин сайдаас төвдөө илгээсэн мэдээ ч ул мөргүй биш нь дээр дурдсан баримтуудаас харагдаж байна.

<sup>5</sup> Равдангийн Болд, “Монголын тусгаар тогтолцоол ба Америкийн Нэгдсэн Улс”, Улаанбаатар, 2008, хавсралт № 19, 377-378 дахь тал

<sup>6</sup> Мон тэнд. Хавсралт № 20, 377-378 дахь тал